

БАТЛАВ.

ХАР НУУР-ХОВД ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Р.ЭНХСҮРЭН



"ЭС ЖИ ГРУПП" ХХ КОМПАНИЙ  
ЗАХИРАЛ Б.СОДНОМПИЛ-Г.



### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2021 оны 08 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 03

Өлгий хот

### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д -д заасны дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2021 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гаргасан 144 дугартай ус ашиглуулах дүгнэлт, Хар нуур-Ховд голын сав газрын захиргааны 2021 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/06 дугартай олгосон Ус ашиглуулах зөвшөөрлийг тус тус үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Хар нуур –Ховд голын сав газрын захиргааны Газар зүйн мэдээллийн систем усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн Солтыкей овогтой Зейнелхан.

Ус ашиглагчийг төлөөлж: "ЭС ЖИ ГРУПП" ХХКомпани Улаанбаатар хот, Хан-Уул дүрэг, 15-р хороо, Махатма Ганди гудамж, ЭМ Эс Эн Бьюлдинг, 801 тоот, 901008070 улсын бүртгэл, 2621169 регистрийн дугаартай "ЭС ЖИ ГРУПП" ХХКомпаний уурхайн дарга Баатар овогтой Содномжамц нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 Ус ашиглах зориулалт: Алтны үндсэн ордыг далд аргаар олборлох, уусган байжуулах

2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1. унд-ахуйд 27,9м<sup>3</sup>/хоног

2.2.2. үйлдвэрлэлт 378,2м<sup>3</sup>/хоног

2.3. Усны эх үүсвэрийн:

Байршил: Ховд гол

Солбицол X-49.0065 Y-89.121357

2.5. Хаягдал усны:

Хэмжээ-88014м<sup>3</sup>/жил

## 2.6. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

- Шавхан зайлуулах усны нөөц ашигласны төлбөр: 11 618 242.02 төгрөг
- Ашигт малтмалбаяжуулахад усны нөөц ашигласны төлбөр: 7 779 111.48 төгрөг
- Зам талбайн тоосжилт дарахад усны нөөц ашигласны төлбөр: 506 909.52 төгрөг

**Нийт төлбөр: 11 618 242.02 + 7 779 111.52 + 506 909.48 = 19 904 263.02 төгрөг**

/ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/

## Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

## Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. аль нэг тал татан буугдсан бол

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- 2021 оны Хаягдал усны дүгнэлтийн 8 дугаар сард багтан гаргуулах.
- Усны тухай хуулийн 30.6-д заасны дагуу Ховд голын эрэг, голдирлыг үл хөндөх, тос масло асгарах, голын эргийн хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх.
- Усны тухай хуулийн 30.1.2 дахь заалтын дагуу ус ашиглалт хариуцсан усны менежертэй байх

- Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримтыг 2021 оны 12 дугаар сарын 01-ны дотор Хар нуур-Ховд голын сав газрын захиргаанд ирүүлэх
- Усны нөөц ашигласны төлбөр болох **19 904 263.02 төгрөг**ийг төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу 2021 оны 10 дугаар сард багтан Баян-Өлгий аймгийн төсөвт төвлөрүүлэх.
- 2021 оны усны нөөц ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.14 дүгээр заалтын дагуу хариуцлага оногдохыг анхаарах.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Хар нуур-Ховд голын СГ Захиргааны  
мэргэжилтэн /С.Зейнелхан/  
Өлгий сум 5-р баг Өлгий сумын ЗДТГазар.

Харилцах утас: 99410555

Ус ашиглагчийг төлөөлж:

"ЭС ЖИ ГРУПП" ХХКомпаний уурхайн  
дарга /Б.Содномжамц/  
Цэнгэл сум, 7-р баг

Харилцах утас: 99377484